



Төрийн албаны  
зөвлөлийн Булган аймаг  
дахь Салбар зөвлөл

# 2024

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

96096326

[www.Bulgan.gov.mn](http://www.Bulgan.gov.mn)




Булган аймаг, Нутгийн  
удирдлагын ордон



# ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

02

## ТУСГАЙ ШАЛГАЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГЭЭР НЭР ДЭВШҮҮЛСЭН ТОГТООЛ



### НЭР ДЭВШҮҮЛСЭН ТОГТООЛЫН АНГИЛАЛ

Төрийн захиргааны төсвийн шууд захирагч	5	▲ 9,6%
Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч	5	▲ 9,6%
Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаал	42	▲ 80,8%

## КОМИСС ТОМИЛОХ ТУХАЙ ТОГТООЛ



## БУСАД ТОГТООЛ

1 1%

Зэрэг дэв олгуулах тухай

1 1%

Шагналд уламжлах тухай

Төрийн захиргааны албанд анх томилогдсон 45 иргэнийг төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэх ёслолын арга хэмжээг зохион байгууллаа.





## **ТӨРИЙН АЛБАНЫ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ХҮРЭЭНД:**

2024 онд төрийн албаны ерөнхий шалгалтын дүнгээр 91 иргэн нөөцөд бүртгэгдсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 2.1.5-д заасан цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөцөд 1, 2.1.6-д заасан гэр бүлийн хүнд өвчтэй аль гишүүнийг асрах зайлшгүй шаардлагын улмаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөцөд 1 нийт 2 иргэн бүртгүүлэх хүсэлт ирүүлснийг баримт бичгийг хянан, үзэж нөөцөд бүртгэсэн.

Байгууллага, иргэний хүсэлтээр нөөцөд бүртгэлтэй эсэх талаар мэдээлэл лавлагааг 2 удаа гаргаж хүргүүллээ.

Нөөцөд бүртгэлтэй иргэдээс 2 иргэн тусгай шалгалтад орж тэнцэн, төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшигдэн, томилогдсон.

2024 оны 12 сарын 31-ний байдлаар Булган аймагт төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд 11 иргэн бүртгэлтэй байна.

<b>№</b>	<b>Үндэслэл</b>	<b>Тоон мэдээлэл</b>
1	Эрүүл мэндийн шалтгаанаар	5
2	Сурахаар	3
3	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу чөлөөлөгдсөн	2
4	Хүнд өвчтэй гэр бүлийн гишүүнээ асрах зайлшгүй шаардлагаар чөлөөлөгдсөн	1
	Дүн	11



## 2.3 ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХҮРЭЭНД:

### А.Ерөнхий шалгалт



Салбар зөвлөлөөс төрийн албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг 3, 5, 9, 11 дүгээр сард 4 удаа төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа.

Ерөнхий шалгалтын бэлтгэл хангах талаар дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- Ерөнхий шалгалтын бэлэн байдлыг хангахад зориулж 2 суурин, 15 зөөврийн компьютер бэлтгэсэн.

- Шалгалтад зориулж хязгааргүй интернэтийн wi fi төхөөрөмж байрлуулан, 1 компьютерт 1 gb хурдаар очихоор хурдыг тохируулсан.

Шалгалт авах компьютер тус бүрийн автомат update татах үйлдлийг бүгдийг хааж шалгалт зохион байгуулагдах явцад интернэтийн хурдад нөлөөлөхгүй байхаар тохируулсан.

Ерөнхий шалгалтын төв комисст zoom программаар шалгалтын үйл ажиллагааг хянах нөхцөлийг бүрдүүлж 1 зөөврийн компьютер, камер байрлуулсан.

Шалгалтын явцыг бичлэг хийж баримтжуулахаар 1 ширхэг камер бэлтгэж, танхимын урд болон хойд хэсэгт байрлуулсан.

- Компьютер гацах, унтарсан тохиолдолд шалгалтыг саадгүй үргэлжлүүлэх нөхцлийг бүрдүүлэн 3 ширхэг компьютер тусгаарлан бэлдсэн.

- Шалгалтын явцыг иргэдэд ил тод хүргэх нөхцөлийг бүрдүүлэн үүдний хэсэгт зурагт байрлуулсан

- Шалгалт өгөх иргэдэд хүндрэл багатай түргэн шуурхай үйлчлэх үүднээс бүртгэлийн ажилтан, хурууны хээ унших төхөөрөмжийг шалгалт авах танхимын үүдэнд байрлуулсан.



Шалгалтын үеэр шалгуулагч иргэд эрүүл мэндийн байдал хүндэрсэн, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн тохиолдол гараагүй.


Шалгалт авч байгаа танхимд цахилгаан доголдоогүй. Эмх замбараагүй байдал үүсээгүй.

Интернэтийн болон цахилгааны тасалдал, доголдол гараагүй.


Шалгалтын үеэр гар утас ашиглахыг оролдсон тохиолдолд сануулж, гар утсыг хураан авч, шалгалтыг дүрэм, журмын дагуу зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

# ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН НӨӨЦ

2024



## Ирц



## ДҮГНЭЛТ

2021-2024 онд төрийн албаны ерөнхий шалгалтад нийт 1468 иргэн оролцсоор бүртгүүлснээс 1114 буюу 75.8 хувь оролцсон. Шалгалтад оролцсон иргэдийн 32.1 хувь тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн байна. Үүнээс хүйсээр ангилж үзвэл:

ЭРЭГТЭЙ	ЭМЭГТЭЙ
57%	43%



## Б.Тусгай шалгалт, сонгон шалгаруулалт

2024 онд төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын нийт 145 албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт, тусгай шалгалтыг 8 удаа зохион байгууллаа.


**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛАХ ЗАР:**

2024 оны 9 сарын 10-ны 09:00 цагаас	2024 оны 9 сарын 14-ний 18:00 цаг хүртэл	
QR кодыг уншуулаад албан тушаалын дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцаарай.		

Bulgan.gov.mn/ТАЭСЗ | 96096326

Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албаны шалгалт өгөх болзол, шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2 дахь заалтын дагуу төрийн жинхэнэ албан хаагчдаас сул орон тоонд шилжүүлэн ажиллуулах зарыг Булган аймгийн албан ёсны хуудас [www.bulgan.gov.mn](http://www.bulgan.gov.mn) хуудсанд журамд заасан хугацаагаар байршуулж, тусгай шаардлага хангасан төрийн жинхэнэ албан хаагчийг сул орон тоонд шилжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн нийт сул орон тоог нөхөх нээлттэй шалгалтын зарыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn), Булган аймгийн албан ёсны цахим хуудас, Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь Салбар зөвлөлийн нүүр номоор иргэдэд өргөн хүрээнд хүртээмжтэй хүргэлээ. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалд нийт 16 иргэнийг тусгай шалгалт, сонгон шалгаруулалтын дүнгээр томилуулахаар эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх тогтоолыг хүргүүлсэн. Тогтоолын хэрэгжилт 100 хувьтай байна.





## 2.4 ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИД ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ ХҮРЭЭНД:

А) Салбар зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх, байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх хяналт, шалгалтыг 1 удаа зохион байгууллаа. Хяналт шалгалтын хүрээнд: 2021 онд Төрийн албаны тухай хууль, тогтоомж зөрчиж томилсныг тогтоосон Төрийн албаны зөвлөлийн тогтоолын биелэлтийг хянах;

1. Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсон эсэх, төрийн албан хаагч нэг бүрийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судлах;
2. Агентлаг нь батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажиллаж байгаа эсэх, төрийн жинхэнэ албаны сул орон тооны мэдээлэл, сул орон тоог нөхөх үйл ажиллагааг хууль, журмын дагуу гүйцэтгэж байгаа эсэх, холбогдох арга хэмжээ авах, зөвлөн туслах;
3. Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн сургалтын үйл ажиллагаатай танилцах;
4. Төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, шаардлагатай тохиолдолд шинэчлэн байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.



ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх, байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Булган сумын Засаг даргын тамгын газар

Гурав. Ажлын хэсэг

Ахлагч:

Д.Алтаншагай – Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн дарга

Гишүүд:

Д.Эрдэнэбилэг - Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Б.Одхүү - Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн


Д.Батцогт - Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн

М.Мөнхбат - Статистикийн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Аймгийн Засаг даргын тамгын газрын холбогдох албан хаагчид

Нарийн бичгийн дарга:

Ч.Баттуяа - Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛ**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг  
Цогт Хүн Тэнгэрийн талбай  
Утас: 7034-2441, Факс: 7034-2350

2024.04.25 № 58

Төвийн \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

АГЕНТЛАГИЙН ДАРГА, СУМДЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА НАРТ

Хуулийн хэрэгжилтийг хангаж  
ажиллах тухай

Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь Салбар зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 17 агентлаг, сумдын Засаг даргын тамгын газар, төрийн байгууллагуудад Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын хэрэгжилт, төрийн захиргааны албан хаагчдын томилгоо, албан тушаалын шаварлага хангаж буй эсэхэд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд хяналт, шалгалт хийж ажиллалаа.

**НЭГ. ШАЛГАЛТЫН МӨРӨӨР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ:**

**А) Төрийн албан хаагчийн хувийн хэргээ хөтлөлт:**

Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрэн бүрдүүлдэггүй. Үүнд:

- Төрийн жинхэнэ албан хаагчдын ерөнхий болон тусгай шалгалт өгснийг нотлох бичиг баримт дутуу;
- Ажил байдлын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, тухайн албан хаагчтай холбоотой тухал, шийдвэр зэрэг бусад бичиг баримтыг бүрэн бүрдүүлээгүй;
- Төрийн албан хаагчийн танилцуулга, анкетын мэдээлэл дутуу;

Байгууллагын удирдлагын зүгээс төрийн албан хаагчийн хувийн хэргэ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрэн бүрдүүлээгүй;

Журмын 6.3-т заасан байгууллагын удирдлага 4 жил тутам хувийн хэргэрт үзлэг шалгалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлдэггүй.

**Б) Төрийн захиргааны албан хаагчийн томилгоо:**

2021 онд Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлөөс хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил арилгасан байдалд хяналт хийхэд 23 байгууллагын 113 зөрчилтэй томилгоог 100 хувь арилгаж ажиллажээ.

2021 оны хяналт шалгалтаас хойш хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Биеийн тамир, спортын газар, Стандарт хэмжээ зүйн хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Татварын газар, Нийгмийн даатгалын газар, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Хануй голын сав газрын захиргаа, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Бугат, Дашинчилэн, Могод, Орхон, Сэлэнгэ, Төв, Хангал, Төст44.2024;D



### Хамрагдсан байгууллагууд:




- Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
- Сумын Засаг даргын Тамгын газар

Сум агентлагийн түвшинд 2021 онд илэрсэн томилгооны зөрчлийг 100% арилгасан. Сум агентлагийн түвшинд 2021 онтой харьцуулахад томилгооны зөрчил 90 хувиар буурсан үр дүнтэй байна.

Хяналт шалгалтын дүнгээр нийт төрийн захиргааны албанд 12 иргэнийг хууль, тогтоомж зөрчиж томилсныг чөлөөлж, томилгоог хуульд нийцүүлэх үүрэг даалгаврыг холбогдох тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Төрийн байгууллагууд байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог байгуулахдаа хүчингүй болсон эрх зүйн акт үндэслэсэн, хамт олноос санал хураагаагүй зэрэг зөрчил илэрснийг “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-д нийцүүлж байгуулах талаар арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулж, нийт 4000 гаруй төрийн албан хаагчдыг хамрууллаа

### Зөрчилтэй томилгоо







Б) Төрийн албаны зөвлөлийн хяналт, шалгалтын ажлын хэсэг Булган аймагт ажиллаж, төрийн жинхэнэ албан хаагчийн томилгоонд тавьж ажиллалаа.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах Төрийн албаны зөвлөлийн “**Хяналт, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай**” 2024 оны 242 дугаар тогтоолын хэрэгжилтэд Салбар зөвлөл хяналт тавьж, төрийн захиргааны албан тушаалын зөрчлийг арилгуулах, хууль зөрчиж томилогдсон болон иргэдийн төлөөлөгчөөр ажиллаж буй албан хаагчдыг төрийн захиргааны албанаас чөлөөлүүлэх арга хэмжээг авч ажиллалаа.

2024.12.20-ны байдлаар зөрчил арилгасан 15, хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа 1 буюу 93,7 хувийн хэрэгжилттэй байна.



В) Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шүүр” ажиллагааны хүрээнд төрийн албанд сонгон шалгаруулалт, тусгай шалгалтгүйгээр томилогдсон иргэдийг чөлөөлж төрийн захиргааны 29, төрийн үйлчилгээний 89 албан хаагчийг чөлөөлүүлэх, тухайн албан тушаалын сул орон тоог хууль, тогтоомжид нийцүүлэн нөхөх ажлыг Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж байна. Авлигатай тэмцэх газраас ашиг сонирхлын зөрчилтэй гэж тогтоосон ч төрийн албанд томилогдсон албан хаагч байхгүй. Томилох эрх бүхий албан тушаалтны хамаарал бүхий этгээд байхгүй төрийн албанд томилогдсон, давуу байдал үүсгэхүйц нөхцөл байдал үүсгэсэн, авлига албан тушаалын гэмт хэрэгт шийтгүүлсэн, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийтлэг хэм хэмжээг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон төрийн албан хаагч байхгүй болно.

Г) Шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрхийг 2-3 жилээр хасах ялаар шийтгэгдсэн Б.Шинэбаяр, Ц.Доржсүрэн, Г.Мэргэнбаатар, Б.Ариунтунгалаг, Б.Лхагвасайхан, Г.Түвшинтөгс, Б.Энхбаяр нарын мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, ял шийтгэлтэй иргэдийн мэдээллийн санд бүртгүүлж, нийтийн албанд томилохгүй байхад хяналт тавин ажиллаж байна.

Д) Төрийн албаны зөвлөлийн баталсан удирдамжийн дагуу 2024.09.11.-10.05-ны хугацаанд аймгийн Засаг иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Байгаль орчны газар, Боловсролын газар, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа, барилга хот байгууллалтын газар, Эрүүл мэндийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Биеийн тамир, спортын газар Санхүүгийн хяналт, аудитын алба, Булган сумын Засаг даргын тамгын газрыг хамруулан гүйцэтгэн, тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.



## 2.4 СУРГАЛТ, СУДАЛГАА, СУРТАЛЧИЛГАА ХИЙХ ХҮРЭЭНД:

2024 онд давхардсан тоогоор 11071 албан хаагч Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хүрээнд мэргэшүүлэх багц цагийн болон бусад чадваржуулах сургалтад хамрагдаад байна.

Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц цагийн сургалтад төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хамруулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж байна.

2024 онд төрийн албанд анх томилогдсоны дараах чиглүүлэх богино хугацааны сургалтад 6, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 17, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц цагийн сургалтад 10, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц цагийн сургалтад 1 албан хаагч тус тус суралцаж байна.




Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг “4-7-10” сургалтад

ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, МЭРГЭЖЛИЙН ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТАД АЛБАН ХААГЧИЙН ТОО



2024 онд давхардсан тоогоор 8000 гаруй албан хаагч оролцож, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.

Засгийн газар, холбогдох салбарын яам, удирдах дээд шатны чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад 6000 гаруй албан хаагч давхардсан тоогоор хамрагдлаа.



Боловсролын зэргээ ахиулах магистрын сургалтад 14 албан хаагч суралцаж байна.

## 2.5 ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ САХИУЛАХ ХҮРЭЭНД:

“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн сургалтыг нийт 151 төрийн байгууллагуудын 4000 гаруй албан хаагчид зохион байгууллаа.







Булган аймагт үйл ажиллагааг явуулж буй нийт төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороог “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн дагуу байгуулан ажиллаж байгаа эсэхэд хяналт хийхэд хүчингүй болсон эрх зүйн акт үндэслэсэн, хамт олноос санал хураагаагүй зэрэг зөрчил илэрснийг “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-д нийцүүлж байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

### Төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо байгуулсан байдал



## 2.6 ТӨРИЙН АЛБАТАЙ ХОЛБООТОЙ ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ХҮРЭЭНД:


2024 онд Салбар зөвлөл нийт 9 хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч 100 хувь шийдвэрлэж ажиллалаа.



## 2.7 ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/296 дугаар захирамжаар "Булган аймгийн Төрийн албан хаагчдын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр /2019-2022/"-ийг хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж жил бүр 20.0 сая нийт 80.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс батлан, төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэхэд зарцуулсан байна.



Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын магистрын зэрэгтэй албан хаагчдын тоо 5%-иар, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны үр дүн дээшилсэн, Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын үр дүн дээшилсэн.Төрийн албан хаагчдын хууль, тогтоомжийн мэдлэг, ур чадвар нэмэгдсэн. Хөтөлбөр хэрэгжихээс өмнөх жилүүдтэй харьцуулахад төрийн албаны хүний нөөцийн хангалт 5 хувиар өссөн. Шинэ залуу төгсөгчид төрийн албанд ажиллаж буй тоо 1 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны XI/03 дугаар тогтоолоор “Аймгийн төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг батлууллаа.

Төрийн байгууллага бүр Төрийн албаны тухай хуулийн 55.3 дугаар зүйлийн 55.1 дэх заалтыг үндэслэн төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулан, санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, гачигдал тохиолдсон үед тусламж үзүүлэх, орон сууцны нөхцөлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуулийн **59, 60, 61** дүгээр заалтын дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад **1.596.574,1** (Нэг тэрбум таван зуун ерэн зургаан зуун сая таван зуун далан дөрөв ) төгрөгийг зарцуулсан байна.

59.1.1.албан томилолтын зардлыг;

59.1.2.албан ажлын хэрэгцээнд хувийн унаа хэрэглэсэн тохиолдолд батлагдсан нормативын дагуу гарсан зардлыг;

59.1.3.гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор ажиллахаар томилогдсон албан хаагчид тээврийн хэрэгсэл, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст тээврийн хэрэгсэл, ачаа тээшийн зардлыг;

59.1.4.төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхад бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан нийт хугацаанд нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;

[/Энэ заалтад 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

59.1.5.төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхад бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөгжлийн бэрхшээлтэй болж, хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлын тодорхой хэсгийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу санхүүжүүлэх, зөрүүг улсын төсвөөс нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;



59.1.6. ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд сувилуулах бол ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож хоёр жилд нэг удаа олгох;

59.1.7. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах;

59.1.8. хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөр.

60.1. Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

60.2. Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг түүний ар гэрт нь олгоно.

60.3. Төрийн албан хаагчид энэ хуулийн 60.2-т заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгох нөхцөл, журмыг Засгийн газар тогтооно.

61.1.5. орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

61.1.7. төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах;

61.1.9. ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох;



## 2.8 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН САРЫН АЯНЫГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ.

Булган аймгийн Засаг даргын Захирамжаар жил бүрийн 11 дүгээр сарын 26-ны өдөр буюу Улс тунхагласны өдрийг Төрийн албан хаагчийн өдөр болгон 2021 онд зарласан. Тус өдрийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс “Ес зүйтэй, мэдлэг чадвартай, хариуцлагатай төрийн алба”-ыг бэхжүүлж, Төрийн албан хаагчдын манлайллыг дээшлүүлэх, шинэлэг санаа санаачилга, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилготой төрийн албан хаагчийн сарын аяныг зохион байгууллаа.

Сарын аяны хүрээнд дараах олон арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлсэн. АЗДТГ, аймгийн ИТХ-ын ахмад, залуу үеийн уулзалтыг хийлээ. Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван үеийн эргэх холбоог бэхжүүлж ахмад үеийнхнийхээ туршлага, мэдлэгийг залуу хойч үедээ өвлүүлэх, харилцан туршлага судлах зорилгоор тус уулзалтыг зохион байгууллаа.



Төрийн албан хаагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, дэмжих, байгууллагын хамтач байдлыг нэмэгдүүлэх, хоорондын харилцаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, соёл урлагаар дамжуулан иргэддээ эерэг сэтгэлгээг түгээх зорилгоор нутгийн захиргааны болон төрийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдыг хамруулан “**Анхдагч Булган**” урлагийн наадам-2024, зохион байгууллаа.





Сарын аяны хүрээнд төрийн байгууллагуудын албан хаагчдын цахим ур чадварыг нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалтыг АЗДТГ, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран зохион байгуулсан. Сургалтаар E-Mongolia ERP систем, Цахим хөгжлийг дэмжих багц хууль, [www.shilen.gov.mn](http://www.shilen.gov.mn) –ний ойлголт хэрэглээ, тайлан хэрхэн гаргах тухай, Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас [www.gov.mn](http://www.gov.mn) тухай, ашиглалтын ур чадварыг дээшлүүлсэн.



Сарын аяны хүрээнд төрийн албан хаагчдын дунд 4 төрөлт спортын тэмцээнийг зохион байгууллаа.







## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

### 4.1 ҮР ДҮН:

1. Сум агентлагийн түвшинд 2021 онд илэрсэн томилгооны зөрчлийг 100% арилгасан
2. Сум агентлагийн түвшинд 2021 онтой харьцуулахад томилгооны зөрчил 90 хувиар буурсан
3. Төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог аймаг дахь нийт төрийн байгууллагууд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийг үндэслэн байгуулсан.

### 4.2 ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ:

1. Салбар зөвлөлд тусгайлан батлагдсан санхүүжилт байхгүйгээс сум орон нутагт томилолтоор ажиллах, гишүүдэд урамшуулал олгох зэрэг зарим үйл ажиллагаа зохион байгуулахад санхүүжилт дутагдалтай байдаг;

### ТАВ. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХАД ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. Ёс зүйн зөрчлийг бүртгэдэг цахим системтэй болох;
2. Салбар зөвлөлийн төсвийн төслийг боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газраар дамжуулан Сангийн яаманд хүргүүлсэн боловч батлагдаагүй. Цаашид Салбар зөвлөлийг бие даасан төсөвтэй болоход дэмжлэг үзүүлэх.